



ХЭНТИЙ АЙМГИЙН  
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 5/04

Мөрөн сум

「Б.Баасандоржийг “Цагаан толгой” багийн  
Засаг даргын албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 12 дахь хавсралт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 82 дугаар тогтоол, “Цагаан толгой” багийн иргэдийн Нийтийн хуралдааны 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Цагаан толгой” багийн 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн багийн иргэдийн Нийтийн хуралдаанаар сонгогдсон (Батмөнхийн Баасандорж)-ийг Авлигатай тэмцэх газрын 05/21505 дугаартай албан бичгээр тухайн албан тушаалд томилоход татгалзах зүйл тогтоогдоогүй байх тул “Цагаан толгой” багийн Засаг даргын албан тушаалд 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн томилсугай.

2.“Цагаан толгой” багийн Засаг дарга (Б.Баасандорж)-ийн үндсэн цалинг ТУТ-1 458 000 (Нэг сая дөрвөн зуун тавин найман мянга) төгрөгөөр, бусад нэмэгдлүүдийг хууль журмын дагуу бодож олгохыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3.“Цагаан толгой” багийн Засаг даргын албан тушаалд томилогдсон (Б.Баасандорж)-д хуулиар хүлээсэн эрх, үүргийг хэрэгжүүлж ажлын гүйцэтгэлдээ бүрэн хариуцлага хүлээж ажиллахыг даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Намжилноров)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ХАТАНБААТАР